



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

185. Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр  
барагдуулах тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай 830

186. Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг  
устгах тухай протокол соёрхон батлах тухай 831

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

187. Шилэн дансны тухай хуулийн  
төсөл буцаах тухай Дугаар 31 831

188. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн  
төсөл буцаах тухай Дугаар 32 831

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

189. Хөтөлбөр батлах тухай Дугаар 30 832

190. Боомтын нэгдсэн захиргаа  
байгуулах тухай Дугаар 45 840

191. Хилийн зарим боомтын талаар авах  
арга хэмжээний тухай Дугаар 46 841

192. Тогтоолын хавсралтад өөрчлөлт  
орлуулах тухай Дугаар 48 842

193. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус  
байгууллагаар гүйцэтгүүлэх тухай Дугаар 49 844

194. Журам шинэчлэн батлах тухай Дугаар 64 844



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 04 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ХОХИРЛЫГ ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛӨӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.2 дахь хэсэг нэмсүгэй:

“4.2.Энэ хуулийн 4.1-д зааснаар барагдуулснаас үлдсэн 50 хувийн хохирлыг хадгаламж, зээлийн хоршооны орлого, мөнгөн хөрөнгөөр барагдуулна.”

**2 дугаар зүйл.** Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг:**

“1.1.Энэ хуулийн зорилт нь хадгаламж, зээлийн зарим хоршооны үүсгэн байгуулагчдын буруутай үйл ажиллагааны улмаас хадгаламж эзэмшигчид учирсан хохирлын тодорхой хэсгийг төрөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах, үлдэгдэл хохирлыг хадгаламж, зээлийн хоршооны орлого, мөнгөн хөрөнгөөр барагдуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

#### **2/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:**

“5.1.Энэ хуулийн 4.1-д заасан хохирлыг улсын төсвийн хөрөнгөөр барагдуулна.”

#### **3/5 дугаар зүйлийн 5.3, 5.4 дэх хэсэг:**

“5.3.Энэ хуулийн 5.2-т заасан орлого, мөнгөн хөрөнгийг нэгдсэн байдлаар төвлөрүүлж хадгаламж, зээлийн хоршооны нийт хохирогчдын үлдэгдэл 50 хувьд хувь тэнцүүлэн олгох бөгөөд хохирогчдын төлбөрийг барагдуулсны дараа энэ хуулийн 4.1-д заасан төлбөрийг улсын төсөвт буцаан төлж дуусгана.

5.4.Энэ хуулийн 5.3-т заасан орлого, мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу явуулна.”

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 04 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТАМХИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУУЛЬ БУС ХУДАЛДААГ УСТГАХ ТУХАЙ ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай протоколыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 04 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар  
хот

### Шилэн дансны тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2014 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шилэн дансны тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 04 дүгээр  
сарын 24-ний өдөр

Дугаар 32

Улаанбаатар  
хот

### Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1. Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2014 оны 2 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар  
хот

**Хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.3.1 дэх заалт, Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2014 оны 4 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавих, шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж шинээр ажлын байр бий болгох, ажилчдад мэргэжлийн ур чадвар олгох, дадлагажуулах сургалт зохион байгуулж ажиллахыг Хөдөлмөрийн сайд Я.Санжмятавт үүрэг болгосугай.

4. Ойн цэвэрлэгээ явуулах газар нутгийн ойд замын хайгуул хийж, ойн зам барьж байгуулах, ойн цэвэрлэгээгээр бэлтгэсэн модон түүхий эдээр модлог шахмал хавтан, шахмал түлш, барилгын материал, дизель түлш, бионүүрс зэрэг шинэ нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх орчин үеийн технологитой үйлдвэрүүд байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалтыг холбогдох яамтай хамтарч шийдвэрлэн, дэмжлэг үзүүлж ажиллахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулгад үүрэг болгосугай.

5. Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхэд шаардлагатай байгаа 15.5 (арван таван тэрбум таван зуун сая) тэрбум хүртэлх төгрөгийг



шийдвэрлэхийг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав нарт даалгасугай.

6. Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Завхан аймгийн Засаг дарга Ж.Жамъянтив, Хөвсгөл аймгийн Засаг дарга А.Эрдэнэбаатар, Архангай аймгийн Засаг дарга Д.Бат-Эрдэнэ, Булган аймгийн Засаг дарга Д.Эрдэнэбат, Сэлэнгэ аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, Төв аймгийн Засаг дарга Д.Баярбат, Хэнтий аймгийн Засаг дарга Ж.Оюунбаатар нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН  
ХӨГЖЛИЙН САЙД**

**С.ОЮУН**

Засгийн газрын 2014 оны 30 дугаар  
тогтоолын хавсралт

### “ОЙН ЦЭВЭРЛЭГЭЭ” ХӨТӨЛБӨР

#### 1. Үндэслэл, шаардлага

Монгол Улсын хэмжээнд 2013 оны байдлаар ойн талбайн 16,0 хувь буюу 2,1 сая га ойд 44,2 сая шоометр хатсан босоо мод, 19,9 сая шоометр хатсан унанги мод, нийтдээ 64,2 сая шоометр цэвэрлэх шаардлагатай модны нөөц байгаа нь түймэр гарах, тархах, хөнөөлт шавж олшрох, голомт үүсэх нөхцөлийг бүрдүүлж, ойг нөхөн сэргээхэд хүндрэл учруулж байна. Ойг цэвэрлэснээр ойн санг хамгаалах, эрүүлжүүлэх, төлөв байдлыг сайжруулах, мөн хэрэгцээт мод (түлээ, ахуйн хэрэгцээ, үртэс)-ны тодорхой хэсгийг хангах нөхцөл бүрдэж нийгэм, эдийн засаг, экологийн ач холбогдолтой болно.

Иймд ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай болж байна.

Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, шаардлага нь дараах нөхцөл байдлаар тодорхойлогдоно:

1.1. Цэвэрлээгүй ой нь түймрийн аюулыг нэмэгдүүлж байна.

Монгол орны байгаль, цаг уурын төлөв байдал нь ой, хээрийн түймэр гарах магадлал өндөртэй нөхцөл байдлыг үүсгэдэг онцлогтой бөгөөд өнгөрсөн 70 жилд дэлхийн дулаарал 0.7 хэмээр нэмэгдсэн бол



манай орны хувьд 2.1 хэм буюу даруй 3 дахин их байгаа нь түймэр гарах нөхцөлийг улам ихэсгэж байна.

Түймэр нь ойн экосистемийг бүрдүүлэгч хүчин зүйлүүдийн оршин тогтнох чадавхид сөргөөр нөлөөлж, шатсан ойд хортон шавж үржих, ойн өвчлөл гарах шалтгаан болохын дээр хүн ам, нийгэм, эдийн засагт ноцтой хохирол учруулж байна.

Сүүлийн 10 жилийн судалгаагаар 100 мянган га талбайд тохиолдох ойн түймрийн давтамж 1.4-7.3 байгаа нь шатамхайн дундаас их зэрэглэлд шилжсэн нь 1 га дахь унанги модны нөөц буюу шатах материалын нөөц 2-3 дахин нэмэгдсэнтэй шууд холбоотой. Ойд цэвэрлэгээ хийснээр түймрийн аюулыг бууруулж, тухайн ойд түймэр гарах магадлалыг багасгана.

#### 1.2. Хөгширсөн болц гүйцсэн ой

Ойн сангийн 76 хувийг болц гүйцэж хөгширсөн, ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд удаа дараа нэрвэгдсэн ой эзэлж байгаагийн зэрэгцээ цэвдэгт хөрс багасч байгаагаас хүчтэй салхинд мод унах үзэгдэл сүүлийн жилүүдэд ажиглагдах боллоо. Энэ нь ойн төлөв байдалд сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болж байна.

#### 1.3. Ойн хөнөөлт шавжийн аюул

Цэвэрлээгүй ой нь үндэс, гол иш, модлогоор хооллогч 160 орчим зүйлийн хөнөөлт шавжийн тоо толгой хэт олшрох таатай нөхцөлийг бүрдүүлж, ойн экосистемийг эмзэг болгож байна.

#### 1.4. Ойн цэвэрлэгээний ажлын өнөөгийн байдал

Ойг эрүүлжүүлэх, ойн эмгэгээс сэргийлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилготой цэвэрлэгээний арга хэмжээг бодлогын хэмжээнд тавих шаардлага зүй ёсоор гарч ирж байна. Улсын хэмжээнд жилд бэлтгэх модны дээд хязгаарыг тогтоож байгаа нь тухайн жилийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хэрэглээний болон түлшний модны хэрэгцээнд зориулагдаж, харин ойн төлөв байдлыг сайжруулах, нөхөн сэргэх нөхцөлийг хангах цэвэрлэгээний ажил хийгдэхгүй өнөөдрийг хүрсэн.

Судалгаанаас улсын хэмжээнд нийт 3.2 сая шоометр мод, модон материалын бодит хэрэгцээ байдаг бөгөөд зөвхөн түлээний хэрэгцээнд 2,060.0 мянган шоометр, ахуйн хуурай модны хэрэгцээнд 948.1 мянган шоометр, үртсэн шахмал түлш үйлдвэрлэхэд 180.0 мянган шоометр мод, модон бүтээгдэхүүн шаардлагатай байна. Энэхүү эрэлт хэрэгцээний



тодорхой хэсгийг ойн цэвэрлэгээнээс гарах бүтээгдэхүүнээр хангах боломжтой. Нөгөө талаар модны эрэлт, нийлүүлэлтийн зохистой харьцааг зөв тодорхойлоогүйгээс хууль бус мод бэлтгэл гарах нөхцөлийг бүрдүүлж байна.

## 2. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Монгол орны ойг цэвэрлэж эрүүлжүүлэх, төлөв байдлыг сайжруулах, түймэр, хөнөөлт шавжийн хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, ойг нөхөн сэргээх, ойн цэвэрлэгээгээр гарсан модоор түлш, ахуйн хэрэгцээний тодорхой хэсгийг хангах, шахмал хавтан, шахмал түлш, барилгын материал болон бусад эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг модон түүхий эдээр хангаж, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх, ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн аж ахуйн нэгжийг чадавхжуулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна:

2.2.1. эмзэг экосистем бүхий ойд сөрөг нөлөөгүйгээр ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэн ойг эрүүлжүүлж, ойн төлөв байдлыг сайжруулан нөхөн сэргээх;

2.2.2. ойн цэвэрлэгээгээр бэлтгэгдсэн модоор модны эрэлт, нийлүүлэлтийг хангах, модон түүхий эд, материалын зохих хэсгийг дэвшилтэт техник, технологиор боловсруулж, импорт орлох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийг дэмжих, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх;

2.2.3. ойн цэвэрлэгээний арга хэмжээнд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн аж ахуйн нэгж, мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх.

## 3. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. “Эмзэг экосистем бүхий ойд сөрөг нөлөөгүйгээр ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэн ойг эрүүлжүүлж, ойн төлөв байдлыг сайжруулан нөхөн сэргээх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болж үхжиж унасан ой, мод бэлтгэсэн талбайн судалгааг хийж, ойн цэвэрлэгээ хийх шаардлагатай талбай, нөөцийг тогтоох;



3.1.2. цэвэрлэгээ явуулах ойд ойгоос мод бэлтгэх талбайг тусгаарлах ажлыг зохион байгуулах;

3.1.3. ойн цэвэрлэгээ явуулах шаардлагатай бүсэд ойн замын хайгуул хийх, зураг төсөв боловсруулах, ойн зам барьж байгуулах;

3.1.4. хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эхний ээлжинд Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө, Хүдэр, Төв аймгийн Мөнгөнморьт, Батсүмбэр зэрэг сумдаас эхэлж, цаашид аймаг сумыг нэмж хамруулах замаар хэрэгжүүлэх;

3.1.5. ойгоос цэвэрлэгээгээр бэлтгэсэн модны 100 шоо метр тутамд 3 га талбайд ой тарьж ургуулах ажлыг холбогдох нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлэх;

3.1.6. “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөртэй холбоотой хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг сурталчлах, нутгийн захиргааны удирдлагуудад тодорхой мэдлэг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах.

3.2. “Ойн цэвэрлэгээгээр бэлтгэгдсэн модоор модны эрэлт, нийлүүлэлтийг хангах, модон түүхий эд, материалын зохих хэсгийг дэвшилтэт техник, технологиор боловсруулж, импорт орлох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийг дэмжих, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. хот суурин газар, ойгүй болон ойн нөөц багатай аймгуудын түлш, ахуйн хэрэгцээний модны тодорхой хэсгийг цэвэрлэгээнээс гарсан модоор хангах ажлыг зохион байгуулах;

3.2.2. модлог шахмал хавтан, шахмал түлш, барилгын материал, дизель түлш, бионүүрс зэрэг шинэ нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах;

3.2.3. олон улсын түвшинд мөрдөгдөж байгаа ойн цэвэрлэгээ, технологийн цавчидас болон шахмал түлшний үйлдвэрлэлийн сонгомол технологийг нутагшуулах судалгаа хийж, загвар үйлдвэрийн төслийг сонгон шалгаруулах.

3.3. “Ойн цэвэрлэгээний арга хэмжээнд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн аж ахуйн нэгж, мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:





3.3.1. хөрөнгө оруулалт, хөрөнгийн зээл болон бусад эх үүсвэрээс буцаан төлөгдөх нөхцөлтэйгөөр ойн цэвэрлэгээний ажилд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж нутагшуулан, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх;

3.3.2. ойн цэвэрлэгээний ажлын хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх иргэд, ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүд, жижиг аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн хөнгөлөлтөөр дэмжин орон нутагт ажлын байр бий болгох;

3.3.3. ойн цэвэрлэгээний ажлыг гардан гүйцэтгэх менежер, мэргэжлийн ажилчин бэлтгэх, давтан сургах;

3.3.4. хөтөлбөрийн хүрээнд гадаад, дотоодын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх.

#### 4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

4.1. Хөтөлбөрийг дараах хугацаанд хэрэгжүүлнэ:

-1 дүгээр үе 2014-2016 он;

-2 дугаар үе 2016-2020 он;

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

4.2.1. улсын болон орон нутгийн төсөв;

4.2.2. аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө;

4.2.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хөрөнгө;

4.2.4. бусад эх үүсвэр.

#### 5. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт

5.1. Ойн цэвэрлэгээний хөтөлбөрийн менежментийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага удирдаж, “Ойн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар хариуцан ажиллана.



5.2. “Ойн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг жил бүр төлөвлөн ажиллаж, хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих, үр дүнг тайлагнах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд оролцогч төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог зохицуулах, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

5.3. Цэвэрлэгээ хийх ойн талбай тусгаарлалтын ажлыг ойн анги, ой зохион байгуулалтын эрх бүхий ойн мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэнэ.

5.4. Ойн цэвэрлэгээний ажлыг ойн мэргэжлийн аж ахуйн нэгж болон ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, ажилгүй иргэдийг оролцуулан гүйцэтгэнэ.

5.5. Ойн мэргэжлийн байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн үйл ажиллагааг “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулах үүргийг сумын болон сум дундын ойн анги хариуцна.

5.6. Төрийн бус байгууллагууд нь ойн цэвэрлэгээний ажил эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, техник технологи, бизнесийн мэдээллээр хангах, төсөл боловсруулахад дэмжлэг тусалцаа үзүүлэх, хөтөлбөрийн болон ойн цэвэрлэгээний ажлын явцад хяналт тавих зэрэг үйл ажиллагааг зохион байгуулахад оролцоно.

5.7. “Ойн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөртэй холбоотой хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг сурталчлах, нутгийн захиргааны удирдлагуудад тодорхой мэдлэг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.

5.8. Аймаг, нийслэлийн байгаль орчны газар, ойн анги, хууль хяналтын байгууллага нь ойн цэвэрлэгээний ажлын явц, технологийн горим, цэвэрлэгээгээр гарсан модны чанар, хэмжээ, ангилал, зэрэглэл, борлуулах, нийлүүлэх, тээвэрлэхэд хяналт тавина.

5.9. “Ойн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны газраас хүлээн авч нэгтгэн жил бүрийн 2 дугаар сарын 10-ны дотор байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх бөгөөд төрийн захиргааны төв байгууллага нь жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт тайлагнана.



## 6. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2020 онд дараах үр дүнд хүрсэн байна:

6.1.1. нийт 315.0 мянган га хүртэлх ойн талбай цэвэрлэгдэж, ойн төлөв байдал сайжирна;

6.1.2. ойн шатах материалын нөөцийг жилд 1,4 орчим сая шоо метрээр багасган, түймрийн аюулын эрсдэлийг 2 дахин бууруулж, иш холтосны хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлж, хамгаална;

6.1.3. хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ойжуулах, ойг нөхөн сэргээх ажлын нөхцөл бүрдэж, 294.0 мянган га-гаас багагүй талбайд ойжуулалт хийж гүйцэтгэнэ;

6.1.4. ойн цэвэрлэгээнээс гарах модлогоор түлшний болон хэрэглээний модны хэрэгцээний тодорхой хэсгийг хангаж, хууль бус мод бэлтгэл эрс буурна;

6.1.5. ойн цэвэрлэгээг тогтмол зохион байгуулалттайгаар хийж, иргэд ойттойгоо зөв харьцах, хайрлан хамгаалах ухамсар, арга барил бий болно;

6.1.6. ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллагууд чадавхижж, ажилгүй иргэд байнгын ногоон ажлын байраар хангагдан, орон нутгийн төсөвт орох орлогын хэмжээ нэмэгдэж, өрхийн амьжиргаанд бодит дэмжлэг үзүүлнэ;

6.1.7. “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийн хүрээнд ойн замыг барьж байгуулах асуудал шийдэгдэж, ойг хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн аялал жуулчлал хөгжих нөхцөл бүрдэнэ;

6.1.8. ойн цэвэрлэгээгээр бэлтгэгдсэн модон түүхий эдийг боловсруулах шинэ техник, технологи нэвтэрч, импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэн модны ашиглалтын түвшин 80-аас доошгүй хувьд хүрнэ.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад жил бүрийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага өмнөх жилийн эцэст тодорхойлон баталж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгнө.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 2 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 45

Улаанбаатар  
хот

### Боомтын нэгдсэн захиргаа байгуулах тухай

Хилийн боомтын тухай хуулийн 16.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хилийн боомтын хяналтын болон аюулгүй байдлыг хангах байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, ерөнхий зохицуулалтаар хангах үүрэг бүхий Боомтын нэгдсэн захиргааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд байгуулсугай.

2. Боомтын нэгдсэн захиргааны орон тооны дээд хязгаарыг 30 хүртэл байхаар тогтоосугай.

3. Замын-Үүд хилийн боомт, Дорноговь аймгийн Замын-Үүд сум болон “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийг хариуцсан Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгч, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрдэх ашигт малтмалын орд газраас уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох, тээвэрлэх ажлыг уялдуулах, хилийн боомтын үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгч, тэдгээрийн ажлын албыг 2014 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

4. Замын-Үүд болон Өмнөговь аймаг дахь Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгч, түүний ажлын алба татан буугдсантай холбогдуулан хаалтын тайлан тэнцэл гаргаж, эд хөрөнгийг Боомтын нэгдсэн захиргаанд шилжүүлэхээр тогтоосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч ажиллуулах тухай” Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 113 дугаар тогтоол, “Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч ажиллуулж эхэлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 251 дүгээр тогтоол, “Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 6 дугаар тогтоолын 6 дугаар зүйл, “Ажлын албаны орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2010 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 109 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



6. Тогтоолыг 2014 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2014 оны 2 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 46

Улаанбаатар  
хот

### **Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30.1, Хилийн тухай хуулийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол, Хятадын улсын хилийн дагуу Монгол Улсын талаас Өмнеговь аймгийн Хүрмэн сумын нутаг Цагаан дэл уулын чиглэлд, Хятадын талаас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн Альшаа зүүн хошууны нутаг Өлзий уулын чиглэлээр хоёр талын зорчигч, ачаа тээврийн “Цагаан дэл уул-Өлзий” байнгын ажиллагаатай авто замын боомт шинээр байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Монгол, Хятадын улсын хилийн хоёр талын зорчигч, ачаа тээврийн, түр ажиллагаатай Хавирга, Баянхошуу, Ханги, Бургастай авто замын боомтуудыг байнгын ажиллагаанд шилжүүлэх, Монгол-Оросын улсын хилийн Алтанбулаг-Хиагт боомтоор зорчигч нэвтрүүлэх ажиллагааг 24 цагийн горимд шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт даалгасугай.

3. Шинээр байгуулах, байнгын ажиллагаанд болон 24 цагийн горимд шилжүүлэх боомтуудад шаардагдах хөрөнгө оруулалтын болон хилийн хяналтын байгууллагуудад нэмэгдэх орон тоо, төсвийн зардлын асуудлыг шийдвэрлэхийг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Гадаад харилцааны сайд Л.Болдод даалгасугай.



4.1. “Цагаан дэл уул-Өлзий” боомт байгуулах газар зүйн байршлыг нарийвчлан тогтоох, хоёр талын боомтын дэд бүтцийг харилцан уялдаатай, ижил түвшинд төлөвлөж, бүтээн байгуулах асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллах талаар хятадын талын холбогдох байгууллагатай тохиролцох;

4.2. Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хэлэлцээрт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар болон Хавирга, Баянхошуу, Ханги, Бургастай боомтыг байнгын ажиллагаанд шилжүүлэх хугацааны талаар хятадын талтай хэлэлцээ хийж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2014 оны 2 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 48

Улаанбаатар  
хот

### **Тогтоолын хавсралтад өөрчлөлт орлуулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын Хүндэт өргөмжлөл, гэрчилгээний тодорхойлолт, дүрэм батлах тухай” Засгийн газрын 1997 оны 51 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Засгийн газрын Хүндэт өргөмжлөлийн тодорхойлолт”-ыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.

1. Монгол Улсын Засгийн газрын “Хүндэт өргөмжлөл”

Монгол Улсын Засгийн газрын “Хүндэт өргөмжлөл” нь Монгол төрийн мандан бадралыг бэлгэдсэн гурван хөлт тулгыг хүндэтгэлийн баганат суурин дээр байрлуулсан зохиомж байна.

Энэ нь “Мөнх тэнгэрийн хүчин дор Төр, улс минь оройн дээд очир лугаа бат оршиж, түмэн олон минь үеийн үед энх амгалан мандан



бадарч байх болтугай. Энэ үйлсэд Таны оруулсан гавьяа зүтгэлийг мөнхжүүлэх ину” гэсэн Монгол ёсны бэлгэдлийг илтгэнэ.

Төрийн тулганы загвар нь Монголын эртний уламжлалт гурван хелтэй, мөнгөлөг өнгөтэй байх бөгөөд баганат суурийг хар ногоон өнгийн хаш үнэт чулуугаар хийсэн байна.

Тулганы диаметр нь 50 мм, өргөн нь 60 мм байна.

Баганат суурин талууд нь 60 мм, өндөр нь 175 мм байна.

Багана нь 20 мм зузаан, 118 мм өргөн давхар суурьтай ба налуу тал дээр нь 60x15 мм алтан шармал ялтас дээр “Хүндэт .....Танд” “Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөл олгов. Он, сар, өдөр” гэсэн бичээс, шагнагдсан хүний овгийн эхний үсэг, нэрийг бичих зай байна.

2. Засгийн газрын 1997 оны 51 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлийн тухай дүрэм”-ийн “Хоёр” дахь хэсгийн 3 дугаар заалтын “500.000 (таван зуун мянган) төгрөгийн” гэснийг “2.000.000 (хоёр сая) төгрөгийн” гэж өөрчилсүгэй.

3. 2014 онд “Засгийн газрын Хүндэт өргөмжлөл”-ийн дагалдах мөнгөн шагналын санхүүжилтэд зориулж 1.500.000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийг энэ оны 6 дугаар сарын 1-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дансанд төвлөрүүлэхийг сайд нарт даалгасугай.

4. “Засгийн газрын Хүндэт өргөмжлөл”-ийн дагалдах мөнгөн шагналын хөрөнгийг цаашид жил бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн багцад тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2003 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 155 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.САЙХАНБИЛЭГ**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 2 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хот

### Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хустайн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үүргийг “Хустай цогцолборт газар” төвөөр гэрээний үндсэн дээр 10 жилийн хугацаагаар гүйцэтгүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд зөвшөөрсүгэй.

2.Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлын гэрээнд холбогдох хууль тогтоомжийг нарийн чанд мөрдүүлэх, санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх, аялал жуулчлал, олон улсын чанартай судалгаа шинжилгээний ажлыг явуулах зарчмын талаар тодорхой тусгаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 186 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН  
ХӨГЖЛИЙН САЙД**

**С.ОЮУН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 2 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
хот

### Журам шинэчлэн батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 151 дүгээр зарлигийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:





1. “Олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах журам”-ыг 1 дүгээр, “Медаль хүртсэн тамирчинд олгох мөнгөн шагналын хэмжээ”-г 2 дугаар, “Олимп, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн тамирчинд сар бүр олгох мөнгөн урамшлын хэмжээ”-г 3 дугаар, “Үндэсний хэмжээний тэмцээний мөнгөн шагналын хэмжээ, түүнийг олгох журам”-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 183 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Ц.ОЮУНГЭРЭЛ**

Засгийн газрын 2014 оны 64 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ОЛИМП, ТИВИЙН НААДАМ, ДЭЛХИЙН ЗЭРЭГЛЭЛИЙН  
ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОЖ МЕДАЛЬ ХҮРТСЭН  
ТАМИРЧИН, ТҮҮНИЙ ДАСГАЛЖУУЛАГЧИЙГ  
ШАГНАЖ УРАМШУУЛАХ ЖУРАМ**

**1. Нийтлэг үндэслэл**

1.1. Олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнах, үе үеийн олимпын наадам (зуны олимп, өвлийн олимп, паралимпын наадам), дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс олимпын спортын жин, зайд медаль хүртсэн Монгол Улсын иргэнийг насан туршид нь сар бүр урамшуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенцийн дагуу дэлхийн допингийн эсрэг агентлагаар хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын спортын холбоодын зохион байгуулсан тэмцээн, наадмын хөтөлбөрт орсон спортын төрлүүдэд Монгол Улсыг төлөөлж оролцсон тамирчин, түүний дасгалжуулагчид мөнгөн шагнал олгоно.



## 2. Тамирчинд олгох мөнгөн шагнал

2.1. Олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчид тэмцээн, наадмын ангилал, тэмцээнд оролцсон тивийн төлөөлөл, тухайн жин,зайд оролцсон өрсөлдөгч орны тамирчны тооноос хамааран дор дурдсан хувь хэмжээгээр мөнгөн шагнал олгоно. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Тэмцээн		Тивүүдийн оролцоо, хувь хэмжээ		Жин, зай тус бүрт оролцсон орны тоо		Мөнгөн шагналын хувь
Ангилал	Нэр	Оролцсон тивүүдийн тоо	Мөнгөн шагналын хувь	Эрэгтэй	Эмэгтэй	
Спортын наадам	Олимп	Оролцогч орны тоо, тивийн төлөөлөл харгалзахгүй				100%
	Паралимп					
	Өсвөр үеийн Олимп					
	Дифлимп, Универсиад, Дэлхийн наадам, Тусгай Олимп	4 - 5	100%	32 болон түүнээс дээш	24 болон түүнээс дээш	100%
		3 хүртэлх	80%	21 - 31	17 - 23	60%
				20 хүртэлх	16 хүртэлх	30%
	Азийн наадам	Тивийн төлөөлөл харгалзахгүй		24 болон түүнээс дээш	16 болон түүнээс дээш	100%
				16 - 23	12-15	60%
				15 хүртэлх	11 хүртэлх	30%
	Олимпын наадмын хөтөлбөрт багтдаг спортын төрлүүдийн тэмцээн	Дэлхийн аварга	4 - 5	100%	32 болон түүнээс дээш	24 болон түүнээс дээш
3 хүртэлх			80%	21 - 31	17 - 23	60%
				20 хүртэлх	16 хүртэлх	30%
Дэлхийн зэрэглэлийн тэмцээн		4 - 5	100%	24 болон түүнээс дээш	17 болон түүнээс дээш	100%
		3 хүртэлх	80%	17 - 23	12 - 16	60%
				17 хүртэлх	11 хүртэлх	30%



Олимпийн наадмын хөтөлбөрт багтдаггүй спортын төрлүүдийн тэмцээн	Дэлхийн аварга	4 - 5	100%	32 болон түүнээс дээш	24 болон түүнээс дээш	100%
		3 хүртэлх	80%	21 - 31	17 - 23	60%
				20 хүртэлх	16 хүртэлх	30%

2.2. Дэлхийн зэрэглэлийн тэмцээнд Их дуулга, Гран при, Дэлхийн цомын тэмцээнүүдийг оруулж тооцно.

2.3. Дэлхийн зэрэглэлийн тэмцээнд тив, бүс нутаг төлөөлөн эсхүл нэр заагдан оролцсон тамирчин, баг медаль авсан тохиолдолд тивийн оролцоо, оролцогч орны тоог харгалзахгүй мөнгөн шагналыг 100 хувь олгоно.

2.4. Дэлхийн зэрэглэлийн тэмцээнүүдэд тамирчны үзүүлсэн хамгийн өндөр амжилтад тохирох мөнгөн шагналыг тухайн жилд нэг удаа оны эцэст олгоно. Энэ хэсгийн заалт нь журмын 2.3 дахь хэсэгт заасан заалтад хамаарахгүй.

2.5. Тамирчны оролцсон жин, зай тус бүрт авсан медальд харгалзах мөнгөн шагналыг олгоно. Тамирчны оролцсон спортын төрлийн тэмцээн нь олон төрлийн нийлбэр дүнгээр амжилтыг нь тооцож медаль олгодог бол зөвхөн нийлбэр дүнгийн медальд ногдох мөнгөн шагналыг олгоно.

2.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчинд энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан тэмцээний ангилалд ногдох мөнгөн шагналыг олгоно.

2.7. Тусгай Олимпийн наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчинд энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтын 3-т заасан Олимпийн наадмын хөтөлбөрт багтдаггүй спортын төрлүүдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний өсвөр үеийн насны ангилалд ногдох мөнгөн шагналыг олгоно.

2.8. Багийн төрлөөр медаль хүртсэн багийн тамирчин тус бүрийн тэмцээний оролцооны статистикийг харгалзан дор дурдсан хувь хэмжээний мөнгөн шагналыг олгоно:



Багийн гишүүн	Нийт оролцоонд хамаарах хувь	Олгох мөнгөн шагналын хувь
Тамирчин	50% - аас дээш	100%
	50% - аас доош	50%

2.9. Тамирчин шатар, зуун буудалт даамын төрлөөр олон улсын их мастер (Гроссмейстер)-ын цол хүртсэн бол Азийн наадмын алтан медальд ногдох мөнгөн шагналыг нэг удаа олгоно.

2.10. Тамирчин хэмжигдэхүүнтэй спортын төрлөөр 2.1 дэх хэсэгт заасан ангиллын тэмцээнүүдэд оролцох үед тив, дэлхийн рекорд шинэчлэн тогтоосон тохиолдолд тухайн тэмцээн, наадмын алтан медальд ногдох шагналын 30 хувьтай тэнцэх мөнгөн шагналыг тивийн оролцоо, оролцогч орны тоог харгалзахгүй олгоно.

### 3. Дасгалжуулагчид олгох мөнгөн шагнал

3.1. Медаль хүртсэн тамирчны дасгалжуулагчид тамирчинд олгох мөнгөн шагналын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналыг олгоно.

3.2. Тамирчин болон багтай 1-ээс дээш дасгалжуулагч ажилласан тохиолдолд дасгалжуулагчийн мөнгөн шагналыг хувь тохирсон гэрээний дагуу хувааж авна.

3.3. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан багийн бүрэлдэхүүнд нэр заагдсан дасгалжуулагчид мөнгөн шагналыг төлөөлүүлж олгоно.

3.4. Тамирчин нь рекорд амжилт тогтоосон тохиолдолд тамирчны мөнгөн шагналтай дүйцэх хэмжээний мөнгөн шагналыг дасгалжуулагчид олгоно.

### 4. Тамирчинд сар бүр олгох мөнгөн урамшил

4.1. Олимп, паралимп болон олимпийн наадмын төрөлд багтдаг спортын төрлийн жин, зай, төрөлд Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний насанд хүрэгчдийн ангилал, жин, зайд Монгол Улсын нэрийн өмнөөс оролцож, медаль хүртсэн Монгол Улсын иргэнд насан туршид нь сар бүр мөнгөн урамшил олгоно.

4.2. Гадаад улсын харъяат иргэн байх үедээ медаль хүртсэн тамирчинд сар бүрийн мөнгөн урамшлыг олгохгүй.



4.3. Тамирчин нь сар бүрийн мөнгөн урамшил авах болзол хангасан бол дараа оны төсвийн жилийн эхнээс эхэлж мөнгөн урамшлыг олгоно.

4.4. Тамирчин сар бүрийн мөнгөн урамшил авах болзол хангасан боловч урамшил олгогдохоос өмнө нас барсан тохиолдолд түүний ар гэрт нь нэг жилийн турш олговол зохих мөнгөн урамшилтай тэнцэх хэмжээний нөхөх олговрыг нэг удаа олгоно.

4.5. Мөнгөн урамшил авч байсан тамирчин нас барсан тохиолдолд тухайн сараар дуусгавар болгож мөнгөн урамшлыг зогсооно.

#### 5. Мөнгөн шагнал, мөнгөн урамшил олгох

5.1. Спортын холбоод нь энэхүү журмын 2.1-д заасан спортын тэмцээн, наадамд оролцохдоо тэмцээн болохоос 14 хоногийн өмнө эрхэлсэн сайдын шийдвэрээр багийн бүрэлдэхүүнийг батлуулсан байна. Багийн бүрэлдэхүүнийг батлуулахад дараах материалыг бүрдүүлнэ:

5.1.1. тэмцээний албан ёсны урилга, заавар;

5.1.2. спортын холбооноос баталсан тэмцээнд оролцох тамирчдын овог нэр, нас, хүйс, оролцох зай, жинг тусгасан мэдүүлэг;

5.1.3. тамирчин болон багтай 1-ээс дээш дасгалжуулагч ажилласан бол мөнгөн шагналын хувь тохирсон гэрээг ирүүлнэ.

5.2. Мөнгөн шагнал авах болзол хангасан тамирчин, дасгалжуулагчийн харьяалах спортын холбоо нь биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад дараах материалыг тэмцээн дууссанаас хойш 30 хоногийн дотор ирүүлнэ. Үүнд:

5.2.1. тамирчин, дасгалжуулагчийг мөнгөн шагналаар шагнуулах тухай хүсэлт;

5.2.2. тэмцээнд медаль авсныг нотолсон Олон улсын спортын холбооны албан ёсны тамга, тэмдэгтэй тэмцээний протокол, дипломны хуулбар;

5.2.3. тухайн тэмцээний мэдээлэл, протоколыг байршуулсан интернэтийн албан ёсны цахим хаяг;

5.2.4. мөнгөн шагналыг шилжүүлэх банкны нэр, дансны дугаар;



5.3. Сар бүрийн мөнгөн урамшил авах болзол хангасан тамирчин нь дараах материалыг бүрдүүлж биеийн тамир спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

5.3.1. тамирчин эсхүл түүний эхнэр, нөхөр, хүүхдийн болон спортын холбооны хүсэлт;

5.3.2. тамирчны амжилтыг гэрчлэх диплом, гэрчилгээний хуулбар;

5.3.3. тухайн тэмцээний протокол, баримтын хувь;

5.3.4. мөнгөн урамшлыг шилжүүлэх банкны нэр, дансны дугаар;

5.3.5. тухайн тамирчин нас барсан бол эхнэр, нөхөр, хүүхэд нь албан ёсны өв залгамжлагч мөн болохыг нь нотлох бичиг баримт;

5.4. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох материалыг хянаж үзээд, мөнгөн шагнал, сар бүрийн мөнгөн урамшил олгох тухай эрхэлсэн сайдын шийдвэр гаргана.

5.5. Энэ журмын 2.4-т заасан болон Олимп, паралимпийн наадмаас медаль авснаас бусад тохиолдолд мөнгөн шагналыг улиралд нэг удаа эрхэлсэн сайдын шийдвэрийг үндэслэн биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас олгоно.

5.6. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь сар бүрийн мөнгөн урамшил авах тамирчдын нэрсийг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор шинэчлэн эрхэлсэн сайдын шийдвэрээр баталж, мөнгөн урамшлыг сар бүрийн 25-ны өдрийн дотор тухайн тамирчны дансанд шилжүүлнэ.

5.7. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь медаль хүртсэн тамирчин, дасгалжуулагчийн талаар мэдээллийн сан бүрдүүлж ажиллана.

5.8. Тамирчин допинг хэрэглэсэн нь тогтоогдож медалиа хураалгасан тохиолдолд мөнгөн шагнал олгохгүй бөгөөд олгосны дараа илэрвэл мөнгөн шагналыг нөхөн төлүүлнэ.

5.9. Хуурамчаар материал бүрдүүлж мөнгөн шагнал авсан тохиолдолд олон улсын спортын холбооноос лавлагаа авч, тухайн тамирчин, дасгалжуулагчид хуульд заасны дагуу хариуцлага тооцно.

Засгийн газрын 2014 оны 64 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

МЕДАЛЬ ХҮРТСЭН ТАМИРЧИНД ОЛГОХ МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ

(сая.төг)

№	Наадам, тэмцээний ангилал, оноосон нэр		Мөнгөн шагналын хэмжээ (Тамирчдын насны ангилал, медалиар)															
	Ангилал	Оноосон нэр	Насанд хүрэгчид						Залуучууд						Өсвөр үе			
			Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл				
1.	Спортын наадам	Олимпын наадам	120.0	60.0	30.0	-	-	40.0	20.0	10.0	-	-	-	-	-	-	-	-
		Паралимпийн наадам	120.0	60.0	30.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
		Дифлимпийн наадам	60.0	30.0	10.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
		Универсиад	-	-	-	30.0	15.0	10.0	-	-	-	-	-	-	-	-	-	-
		Дэлхийн спортын наадам	15.0	8.0	4.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
		Дэлхийн оюуны наадам, Дэлхийн тулааны наадам	10.0	6.0	3.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
		Азийн наадам	30.0	15.0	10.0	-	-	-	-	-	-	7.0	5.0	4.0	-	-	-	
		Азийн элсний, танхимын, тулааны наадам	8.0	4.0	2.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	



2.	Олимпын наадмын хөтөлбөрт багтдаг спортын төрлийн тэмцээн	Дэлхийн аварга	40.0	25.0	20.0	15.0	10.0	8.0	7.0	5.0	4.0	3.0	2.0		
		Дэлхийн зэрэглэлийн тэмцээн	15.0	8.0	5.0	-	-	-	-	-	-	-	-	-	
	3.	Олимпын наадмын хөтөлбөрт багтдаггүй спортын төрлийн тэмцээн	Дэлхийн аварга	10.0	7.0	5.0	7.0	5.0	3.0	4.0	3.0	2.0	3.0	2.0	
			Дэлхийн зэрэглэлийн тэмцээн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
			Олимпын аварга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
			Олимпын зэрэглэлийн аварга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
			Олимпын наадмын аварга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
			Олимпын зэрэглэлийн аварга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
			Олимпын наадмын зэрэглэлийн аварга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
			Олимпын наадмын зэрэглэлийн аварга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-





Засгийн газрын 2014 оны 64 дүгээр  
тогтоолын 3 дугаар хавсралт

ОЛИМП, ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНЭЭС  
МЕДАЛЬ ХҮРТСЭН ТАМИРЧИНД САР БҮР ОЛГОХ  
МӨНГӨН УРАМШЛЫН ХЭМЖЭЭ

№	Тэмцээний нэр	Хүртсэн медаль	Урамшлын хэмжээ (сая.төг)
1.	Олимпийн наадам (Зуны олимп, өвлийн олимп, зуны паралимп, өвлийн паралимп)	Алт	4.0
		Мөнгө	3.0
		Хүрэл	2.0
2.	Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (Олимпийн наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлийн зай, жинд)	Алт	2.0
		Мөнгө	1.0
		Хүрэл	0.5

Засгийн газрын 2014 оны 64 дүгээр  
тогтоолын 4 дүгээр хавсралт

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ТЭМЦЭЭНИЙ МӨНГӨН  
ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний хэмжээнд Засгийн газрын тогтоолоор зохион байгуулж байгаа Монголын бүх ард түмний, хүүхдийн, оюутны, үндэсний спортын их наадам, биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгогдсон улсын аварга шалгаруулах тэмцээн (цаашид “тэмцээн” гэх)-д амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг мөнгөн шагналаар шагнахад энэхүү журмыг мөрдөнө.



## 2. Шагналын хувь хэмжээ

2.1. Медаль хүртсэн тамирчинд дор дурдсан хэмжээний мөнгөн шагнал олгоно:

№	Тэмцээний		Медалийн төрөл	Мөнгөн шагналын хэмжээ (мян.төг)
	Ангилал	Зэрэглэл		
1.	Спортын их наадам	Монголын бүх ард түмний	Алт	1,500.0
			Мөнгө	1,000.0
			Хүрэл	500.0
		Оюутны, үндэсний, хүүхдийн	Алт	600.0
			Мөнгө	400.0
			Хүрэл	200.0
2.	Улсын аварга	Насанд хүрэгчид	Алт	600.0
			Мөнгө	400.0
			Хүрэл	200.0
		Залуучууд, Өсвөр үе	Алт	400.0
			Мөнгө	200.0
			Хүрэл	100.0

2.2. Багийн спортын төрөл, спортын төрлийн багийн төрөлд дасгалжуулсан баг нь медаль авсан бол багийн дасгалжуулагчид энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан тэмцээний ангиллын дагуу ногдох мөнгөн шагналыг олгоно.

2.3. Багийн спортын төрлөөр медаль хүртсэн тамирчин тус бүрийн тэмцээний турш талбайд тоглосон нийт хугацааны статистикийг харгалзан дор дурдсан хувь хэмжээний мөнгөн шагналыг олгоно:

Багийн гишүүн	Нийт тоглосон хугацаанд хамаарах хувь	Олгох мөнгөн шагналын хувь
Тамирчин	50% - аас дээш	100%
	50% - аас доош	50%



2.4. Хэмжигдэхүүнээр амжилтыг нь тооцдог спортын төрлөөр Монгол Улсын рекорд амжилтыг шинэчлэн тогтоосон тохиолдолд тухайн насны улсын аварга шалгаруулах тэмцээний шагналын 30 хувьтай тэнцэх хэмжээний урамшлыг нэмж олгоно.

2.5. Улсын аварга шалгаруулах тэмцээний жин, зайд оролцсон тамирчны тоо, өрсөлдөөний чанараас хамааран тамирчинд дор дурдсан хувь хэмжээний мөнгөн шагнал олгоно:

Улсын аварга шалгаруулах тэмцээн	Жин, зай, төрөл тус бүрт оролцсон тамирчны тоо		Олгох мөнгөн шагналын хувь хэмжээ
	Эрэгтэй	Эмэгтэй	
Насанд хүрэгчид	16-аас дээш	14-өөс дээш	100 хувь
	9-15	8-13	80 хувь
	8-аас доош	7-оос доош	60 хувь
Залуучууд, өсвөр үе	14-өөс дээш	12-оос дээш	100 хувь
	8-13	7-11	80 хувь
	7-оос доош	6-аас доош	60 хувь

### 3. Үндэсний хэмжээний тэмцээний мөнгөн шагнал олгоход тавих шаардлага

3.1. Тэмцээн зохион байгуулсан спортын холбоо нь тэмцээний тайлан, протоколыг тэмцээн дууссанаас хойш 21 хоногийн дотор биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3.2. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь спортын холбоодоос ирүүлсэн тэмцээний протокол, тайланг хянаж үзсэний үндсэн дээр тамирчин, дасгалжуулагчдын мөнгөн шагналыг тухайн асуудлыг эрхэлсэн сайдын шийдвэрээр олгоно.

3.3. Дараах тохиолдолд мөнгөн шагналыг олгохгүй:



3.3.1. тэмцээний протокол, тайлан, тамирчинд олгох мөнгөн шагналтай холбоотой материалын бүрдэл дутуу;

3.3.2. материалыг хугацаанд нь ирүүлээгүй;

3.3.3. өсвөр үе, залуучуудын тэмцээнд нас дарж орсон.

3.4. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь мөнгөн шагнал хүртсэн тамирчин, дасгалжуулагчийн талаар мэдээллийн сан бүрдүүлнэ.

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medelel@parliament.mn](mailto:turiin_medelel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

**Индекс: 14003**